



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/60

Улаанбаатар хот

Газрын зөрчил арилгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.3.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэг, 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайг нэмэгдүүлэх зорилгоор хууль, журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс, зөвшөөрөлгүй түргэн үйлчилгээний цэг, барилга байгууламж, бусад бүх төрлийн объект барьсан, байршуулсан иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, зөрчил арилгах арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Энэ захирамжийг хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйн болон бусад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.1.Ажлын хэсгийн гаргасан шийдвэрийн дагуу газар чөлөөлөлтийг зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Б.Лхагва-Эрдэнэ)-нд,


3.2.Газар чөлөөлөхөд шаардлагатай техник хэрэгсэл, авто машин механизм, хүн хүчээр хангаж ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ (Х.Нэмэхбаяр), Захиалагчийн алба ОНӨААТҮГ (Д.Алтанхуяг)-т,

3.3.Зөрчил арилгасан байршлуудад шаардлагатай тохиолдолд тохижилтын зураг төсөл боловсруулж батлуулан тохижилт хийхийг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (С.Нямдорж)-т, Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс (Д.Мөнгөндалай)-т,

3.4.Газар чөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлж, хэв журам сахиулж ажиллахыг дүүргийн Цагдаагийн газар (Г.Байдраг)-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжид заасан арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухай бүрд батлуулж дүүргийн 2026 оны төсөвт туссан "Газар чөлөөлөх зардал"-аас гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунзаяа)-д зөвшөөрсүгэй.

5.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангах, явц, үр дүнг танилцуулж ажиллахыг дүүргийн Менежер (Д.Баярсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.БАТТӨР

9023100758  
9091904 - СБТ23271




۶... بنام منجمین نام رسیده که در رتبه سی و دو . اندر همسر محمدجعفر (بن سرتاسر . کتبه . بنام احمد بن  
صنعتشماره سی و دو در رتبه (۶۰... و کتبه) - بی بروی و کتبه ..

۷... و همسر

همسر سعید

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн  
А/60 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Дүүргийн менежер

Гишүүд:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ-ын захирал

Захиалагчийн ажлын алба ОНӨААТҮГ-ын захирал

Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн 1,2,3 дугаар хэлтсийн дарга нар

Газар зохион байгуулалтын албаны дарга

Нарийн бичиг:

Газар зохион байгуулалтын албаны Ахлах мэргэжилтэн